



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Тэшиг сумын Ойн ангийн 2025 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2026/01/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn</p> <p>Булган аймаг 2026 он</p>	<p>Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Д.Батцогт Утас:7034-2580 Цахим хаяг: Bulgan@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас:9905-7478 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитор: С.Цэдэнлхам Утас:9982-8263 Цахим хаяг: Tsedenkham@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580

Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.03.13 № 318

танай _____ ны № _____ т

ТЭШИГ СУМЫН ОЙН АНГИЙН
ДАРГА Г.СҮХБАТ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Тэшиг сумын ойн ангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Тэшиг сумын ойн ангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тэшиг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор Тэшиг сумын Ойн ангийн 2025 оны төсвийг 63.4 сая төгрөг байхаар баталсан байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

6326950533

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д. БАТЦОГТ

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

(мянган төгрөгөөр)

	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	760.8	6,515.3
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,309.9	27,251.8
	Нийт хөрөнгийн дүн	4,070.7	33,767.1
	Нийт өр төлбөрийн дүн	16.0	12.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,054.7	33,755.1
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,070.7	33,767.1
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	56,259.8	102,056.2
	Үйл ажиллагааны зардлын дүн	59,345.8	72,355.8
	Үйл ажиллагааны үр дүн	(3,086.0)	29,700.4
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(3,086.0)	29,700.4
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,054.7	42,786.7
	Тайлант оны үр дүн	38,732.0	29,700.4
	Эцсийн үлдэгдэл	42,786.7	72,487.1
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	56,250.8	68,929.5
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	57,727.2	63,382.5
	Үйл ажиллагааны ЦМГ	(1,476.4)	5,547.0
	Хөрөнгө оруулалтын ЦМГ		
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(1,476.4)	5,547.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	57,727.2	63,382.5
	Урсгал зардал	57,727.2	63,382.5
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	56,250.8	68,929.5
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	42,750.0	42,750.0
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,500.8	26,179.5

Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тэшиг сумын Ойн анги нь Байгаль орчныг хамгаалах тухай, Ойн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, Ойг хамгаалах нөхөн сэргээх зорилготой.

2025 онд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулан батлуулах, “Хорин сая мод тарих” хөдөлгөөнийг зохион байгуулах, мод бэлтгэлийн талбай тусгаарлалтыг зохион байгуулах, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, иргэдтэй гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах, ойн хортон шавжийн тойм судалгаа хийх, тэмцлийн ажилд хяналт тавих, идэвхтэн байгаль

хамгаалагч, морин эргүүлийг ажиллуулах, ойн нөхөрлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллах зэрэг арга хэмжээг төлөвлөн ажилласан байна.

Тэшиг сумын ойн анги нь үйл ажиллагаандаа Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Ойн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Шилэн дансны тухай, Татварын багц, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон түүнийг дагалдан гарсан тогтоол, дүрэм журам, эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангаж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан үйл ажиллагаа явуулдаг.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль,
- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгавар
- Тэшиг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 14 дүгээр тогтоо

Дөрөв. Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тэшиг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор Тэшиг сумын Ойн ангийн 2025 оны төсвийг 63.4 сая төгрөг байхаар баталсан байна.

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Тав. Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 23 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тэшиг сумын Ойн анги нь тайлант онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулах бүх мэдээллийг ил тод байршуулан ажилласан байна.

Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д, санхүүгийн төлөвлөгөө, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, батлуулж, биелэлтийг гаргаж ажиллах нь зүйтэй гэж үзэж байна

Найм. Аудитын илрүүлэлт:

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

